



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2004 оны 9 сарын 21 өдөр

Дугаар 329

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын 2,6-г үндэслэн ТУШААХ НЬ:

1. Виктор овогтой Сарангэрэлийг АНУ-ын Де Врай Их сургуулийн магистрантурт банк, санхүүгийн удирдлагын чиглэлээр, Лхагвасүрэн овогтой Мөнхсүрэнг Япон улсын Нагояа хотын Айчи Их сургуулийн магистрантурт гадаад худалдааны чиглэлээр, Алтангэрэл овогтой Төвшинг БНСУ-ын Сөүлийн Их сургуулийн магистрантурт график дизайны чиглэлээр тус тус 2 жилийн хугацаагаар 2004-2005 оны хичээлийн жилээс суралцуулсугай.

2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД

А.ЦАНЖИД